


# ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

## ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**Судалгаа Статистикийн газар,  
Судалгааны хэлтэс**

*Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн эдийн засгийн төлөө байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.*



# ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

1-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2017 ОНЫ IV УЛИРАЛ

## 1. Иргэдийн Инфляцийн Хүлээлт


Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн 845 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- Иргэд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны I улиралд 6.6%, 2018 оны IV улиралд 7.9% байхаар; ii) тоон хариултын хувьд 2018 оны I улиралд 5.1%, 2018 оны IV улиралд 5.8% байхаар; iii) мэдрэмж (үнийн дарамтыг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны I улиралд 5.5%, 2018 оны IV улиралд 11.4% байхаар тус тус хүлээж байна;
- Иргэдийн хувьд зээлийн хүү ирээдүйд бага зэрэг өснө гэж хүлээж байна;
- Иргэд эдийн засгийн байдал сайжирч, өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй байна;
- Иргэд Төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлттэй хэвээр байна;

### 1.1. Инфляцийн хүлээлт

Чиглэлийн индексээс харахад 2017 оны эхэн үеэс иргэдийн үнийн өсөлтийн талаарх хүлээлт хандлагаараа өсч ирсэн байна. Энэ удаагийн судалгааны үр дүнг 2017 оны III улирлын дүнтэй харьцуулахад үнийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлт бага зэрэг (ялимгүй) өсчээ. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшнээс бага зэрэг өснө гэсэн хандлага давамгайлж байна /Зураг 1-1/.

Зураг 1- 1: Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа.

Зураг 1- 2: Иргэдийн инфляцийн хүлээлт /чанарын болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Иргэдийн инфляцийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход иргэд инфляцийг 2018 оны I улиралд 6.6%, 2018 оны IV улиралд 7.9%-тай байхаар хүлээж байна. Мөн иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2018 оны I улиралд 5.1%, 2018 оны IV улиралд 5.8%-тай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /perceived inflation/<sup>2</sup> 2018 оны I улиралд 5.5%, 2018 оны IV улиралд 11.4%-тай байхаар хүлээгдэж байна /Зураг 1-2/.

Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 70% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 29% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (өмнөх судалгааны дүнгүүдээс өссөн), 41% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ /Зураг 1-3/


Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултаудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд буюу 2018 оны I улиралд 5.1%, жилийн дараа буюу 2018 оны IV улиралд 5.8%-тай байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд ирэх 12 хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 1-4/.

Харин 2018 оны эцсийн инфляци 6%-8% байна гэсэн хариултыг хамгийн их давталттай өглөө.

**Зураг 1- 3: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?**



**Зураг 1- 4: Иргэдийн инфляцийн хүлээлтийн тархалт /тоон хариултаар**




Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

<sup>2</sup>-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.


Иргэд 2018 оны IV улирлын хүнсний бус бүтээгдэхүүний инфляцийг 5.5%, хүнсний бүтээгдэхүүний инфляцийг бага зэрэг өндөр буюу 5.8%-тай байхаар хүлээж байна /Зураг 1-5/. Хариултын тархалтаас харахад дараа жилийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 6%-8% байх хариулт хамгийн олон давталттай байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 87% нь 2018 оны I улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2018 оны IV улиралд иргэдийн 77% нь инфляци зорилтот түвшнээс бага байна гэж үзжээ /Зураг 1-6/.

**Зураг 1- 5: Инфляцийн хүлээлтийн тархалт /хүнсний, хүнсний бус, ирэх 12 сар/**



**Зураг 1- 6: Инфляцийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/**



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

## 1.2. Эдийн засгийн өсөлт, иргэдийн орлого

Эдийн чиглэлийн индекс өмнөх улирлын судалгааны дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн байдал сайжрах төлөв ажиглагдана гэсэн эерэг хүлээлттэй байна. Засгийн газар ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах болсноор эдийн засагт бодлогын эерэг өөрчлөлтүүд гарна гэсэн хүлээлт нь иргэдийн дунд эдийн засгийн байдал тогтворжиж, цаашид сайжирна гэж үзэхэд нөлөөлсөн байх боломжтой /Зураг 1-7/.


Энэ удаагийн иргэдийн өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индексээс харахад иргэдийн дийлэнхи нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-8/.

Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжрахын хирээр өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

## 1.3. Валютын ханшийн хүлээлт

Ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн иргэдийн хувьд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт огцом нэмэгдсэн, улмаар 2017 оны 4-р улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт өндөр хэвээр байгаа нь төгрөгт итгэх иргэдийн итгэл өндөр байгааг илэрхийлнэ /Зураг 1-9/.

**Зураг 1- 7: Ирэх 12 сарын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



**Зураг 1- 8: Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



Тайлбар: Чиглэлийн индекс [-1;1] завсарт утгаа авна. [0; 1] эдийн засгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0; -1] муудна.

**Зураг 1- 9 Ирэх 12 сарын хугацаанд валютын ханшийн талаарх хүлээлт**




Эх сурвалж: Монголбанк, иргэдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

### 1.4. Хүүний түвшний ирээдүйн хандлага


Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү бага өндөр хэвээр байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-10/.

Санал асуулгад оролцсон иргэдийн 25% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өснө гэж үзсэн бол 56% нь хэвэндээ, 19% нь хадгаламжийн хүү буурна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл иргэд ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өнөөгийн түвшинд байна гэж үзжээ /Зураг 1-11/.

**Зураг 1- 10: Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



**Зураг 1-11 Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/**



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

# АЖ АХУЙ НЭГЖИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2017 ОНЫ IV УЛИРАЛ



## 2. Аж Ахуй Нэгжийн Инфляцийн Хүлээлт


ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 4-ний өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 346 бизнес эрхлэгчдээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- ААН-үүд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны I улиралд 3.3%, 2018 оны IV улиралд 3.7%; ii) тоон хариултын хувьд 2018 оны I улиралд 5.2%, 2018 оны IV улиралд 6.0%; iii) мэдрэмж (үнийн өсөлтийн дарамт мэдрэгдэж буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны I улиралд 3.3%, 2018 оны IV улиралд 3.9% байхаар тус тус хүлээж байна;
- ААН-үүдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт давамгайлж байна. Энэ нь төгрөгт итгэх итгэл өндөр байгааг илтгэж байна;
- ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байгаа бөгөөд цалингийн түвшин бага зэрэг өснө гэж хүлээж байна;
- ААН-үүдийн 20 орчим хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр ажлын байр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна;

### 2.1. Инфляцийн хүлээлт

Инфляцийн хүлээлтийн талаарх чиглэлийн индексээс харахад 2017 оны III, IV улиралд инфляцийн хүлээлт бага зэрэг өсч ААН-үүд инфляцийг өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж үзэж байна /Зураг 1.1/.

**Зураг 1-12 ААН-ийн үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/**



**Зураг 1-13 ААН-ийн инфляцийн хүлээлт /чанар ба тоон хариултаар/**



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

<sup>1</sup>-Өснө, буурна гэсэн хариултуудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ ААН-үүдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.

Аж ахуйн нэгжийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход ААН-үүд инфляцийг 2018 оны I улиралд 3.3%, 2018 оны эцэст 3.7%-тай байхаар хүлээж байна.

ААН-ийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд 5.2%, жилийн дараа буюу 2018 оны IV улиралд 6.0%-тай байхаар хүлээж байна. Ирэх оны инфляцийг 6-8 хувьд байна гэсэн хариулт хамгийн өндөр давталттай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /perceived inflation<sup>2</sup> 2018 оны I улиралд 3.3%, 2018 оны IV улиралд 3.9%-тай байхаар хүлээж байна /Зураг 1.2/.


Судалгаанд хамрагдсан ААН-ийн 85% нь 2018 оны I улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2018 оны IV улиралд ААН-ийн 75% нь инфляци зорилтот түвшнээс бага байна гэж хүлээжээ /Зураг 1.4/.

## 2.2. Валютын ханш, зээлийн хүүний хүлээлт


Ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны IV улиралд чиглэлийн индекс огцом буурч сүүлийн 6 жилийн хугацааны хамгийн бага утганд хүрсэн юм. Өөрөөр хэлбэл, ААН-үүдийн дунд ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнөөдрийн түвшнээс илүү чангарна гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 2.1/. Энэ нь ААН-үүдийн төгрөгт итгэх итгэл өндөр байгааг илтгэнэ.

<sup>2</sup>-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.

**Зураг 1-14 ААН-ийн инфляцийн хүлээлт /тархалт, тоон хариултаар/**



**Зураг 1-15 ААН-ийн инфляцийн хүлээлт /хуримтлагдсан тархалт, тоон хариултаар/**



**Зураг 2-1 Ирэх 12 сарын хугацаан дахь валютын ханшийн хүлээлт**



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Чиглэлийн индекс анх удаа ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү буурна гэсэн утгатай гарав /Зураг 2.2/.

### 2.3. Аж ахуй нэгжийн үйл ажиллагаа

ААН-үүд өнгөрсөн 6 сарын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт харьцангуй тогтвортой байсан гэж үзжээ. Харин ирэх 6 сарын хугацаанд бизнес эрхлэгчид борлуулж буй барааны эрэлт нь нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна /Зураг 3.1/.


Эдийн засгийн хүндрэлээс гарч, бизнесийн идэвхжил бага зэрэг нэмэгдсэнээр ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч, улмаар ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд ажлын байрыг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй болжээ. Мөн цалинг ирэх 6 сарын хугацаанд бага зэрэг нэмэгдэнэ гэж хүлээж байна /Зураг 3.2/.

Судалгаанд оролцогч бизнес эрхлэгчдийн 30% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний тулд ихэнхи ААН банкны зээлээр (31%) болон өөрийн хөрөнгөөр (37%) санхүүжүүлнэ гэж хариулсан /Хавсралт 1-3/.


**Зураг 2-2 Ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүүний хүлээлт**



**Зураг 3-1 Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт /өнгөрсөн 6 сар болон ирэх 6 сард/**




**Зураг 3-2 Ирэх 6 сарын хугацаанд ажлын байр болон цалингаа нэмэгдүүлэх эсэх**



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Тайлбар: Индекс [-1;1] завсарт утгаа авна. ]0;1] өснө, [0] өөрчлөгдөхгүй, ]0;-1] буурна.



**ШИНЖЭЭЧДИЙН  
ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ**  
**3-Р БҮЛЭГ**



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2017 ОНЫ IV УЛИРАЛ

### 3. Шинжээчдийн Инфляцийн Хүлээлт



Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаанд арилжааны банкууд болон их дээд сургуулиудын судлаач, багш нарыг хамрууллаа. Шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаанд эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн нийт 19 судлаачдын инфляци, эдийн засгийн өсөлт, валютын ханш, бодлогын хүү болон зээлийн хүүний ирэх 12 сарын таамаглалыг нэгтгэн тооцлоо. Судалгааны үр дүн дараах байдлаар харагдаж байна /Хүснэгт 1/.

#### 3.1. Инфляцийн хүлээлт

Шинжээчид инфляцийн түвшинг 2017 оны эцэст 7.0%, 2018 оны эцэст 8.1% байхаар таамаглаж байгаа нь зорилтот түвшний ойролцоо үзүүлэлт юм. Инфляцийн түвшинг 2017 оны эцэст хамгийн ихдээ 8.4%, 2018 оны эцэст хамгийн ихдээ 12%-д хүрнэ гэж хүлээж байна /Зураг 1-1/.

Инфляцийн таамаглалын гистограмм буюу харьцангуй давтамжаар нь авч үзвэл шинжээчдийн дунд инфляцийг 2018 оны эцэст 8.4%-д хүрнэ гэсэн хүлээлт давамгайлж байна. Энэ нь судлаачдын дунд ирэх онд инфляцийн түвшин өнөөгийн түвшнээс бага зэрэг өсч, зорилтот инфляцийн түвшний ойролцоо байна гэсэн хүлээлт давамгайлж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм /Зураг 1-2/.

Хүснэгт 1: Судалгааны товч үр дүн	
Инфляцийн таамаглал	
Цаашид өсч ирэх оны эцэст дунджаар 8.1%	[3.4%-12%]-ийн интервалд байна гэж таамагласан.
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	
Төгрөгийн ханш чангарна гэж хүлээж байна.	Ирэх онд [2000₮-2580₮]-ийн интервалд таамагласан.
Мөнгөний бодлого, зээлийн хүү	
Бодлогын хүү буурна	Зээлийн хүү буурна гэсэн хүлээлттэй байна.
Эдийн засгийн өсөлт	
Эдийн засгийн өсөлт ирэх оны эцэст 5.0%-тай байна гэж таамаглаж байна.	



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Шинжээчид 2017 оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг чангарах буюу дунджаар 2,451 төгрөг, 2018 оны эцэст мөн л өнөөгийн түвшнээс доогуур буюу 2419 төгрөгийн орчимд байхаар хүлээж байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг шинжээчид 2018 оны эцэст хамгийн ихдээ 2,580 төгрөг, харин хамгийн багадаа 2,000 төгрөгт хүрнэ гэж таамаглаж байна.

2017 оны 3-р улиралд шинжээчид ханшийг 2017 оны эцэст 2,460 байхаар таамаглаж байсан бол энэ удаа төгрөг чангарна гэсэн хүлээлт шинжээчдийн дунд өсчээ /Зураг 1-3/.

Хэдийгээр шинжээчдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт давамгайлж байгаа боловч ханшийн гистограммыг авч үзвэл төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2,500-д хүрнэ гэж үзэж байгаа судлаачид цөөнгүй байна /Зураг 1-4/.


Шинжээчид бодит ДНБ-ий өсөлтийг 2017 оны эцэст дунджаар 4.5%, дараа оны эцэст 5.1%-д хүрнэ гэж хүлээж байна. Харин зарим шинжээчид 2018 оны эцэст эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр буюу хамгийн ихдээ 8.0%-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна. 2017 оны 3-р улиралд шинжээчид бодит ДНБ-ийн өсөлтийг оны эцэст 3.5%-д хүрнэ гэж таамаглаж байсантай харьцуулахад өнөөдрийн хүлээлт даруй 1.0%-иар нэмэгджээ /Зураг 1-5,6/.

Судлаачдын таамаглалын гистограммыг авч үзвэл 2018 оны эцэст бодит ДНБ-ий өсөлт 5%-6%-д хүрнэ гэж нийт судлаачдын дийлэнх хувь нь хүлээж байна.

**Зураг 1- 18 Ханш /таамаглал/**




**Зураг 1- 19 Ханшийн таамаглалын гистограмм /2017 оны эцэст/**



**Зураг 1- 20 Бодит ДНБ-ий өсөлт /таамаглал/**



**Зураг 1- 21 Бодит ДНБ-ий өсөлт гистограмм /таамаглал, 2018 оны эцэст/**



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Шинжээчид ирэх 12 сарын хугацаанд бодлогын хүү өнөөгийн түвшнээс буурч 2018 оны эцэст 10.0%-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, шинжээчдийн дунд ирэх 12 сарын хугацаанд Монголбанкыг мөнгөний бодлогоо зөөлрүүлнэ гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 1-7/.

Бодлогын хүүний таамаглалын гистограммыг харахад 2018 оны цэст бодлогын хүү 10%-11% байна гэсэн хүлээлт хамгийн өндөр байна /Зураг 1-8/.


Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг шинжээчид дараа оны эцэст өнөөгийн түвшнээс буурч дунджаар 18.5%-ийн орчимд байна гэж хүлээж байна. Шинжээчид тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2018 оны эцэст хамгийн ихдээ 22.0%, хамгийн багадаа 15.0%-тай байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-9/.

Шинжээчдийн дийлэнх нь ирэх оны эцэст зээлийн хүү 17%-21% байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-10/.

**Зураг 1- 22 Бодлогын хүү /таамаглал/**




**Зураг 1- 23 Бодлогын хүүний гистограмм /таамаглал, 2018 оны эцэс/**



**Зураг 1- 24 Зээлийн хүү /таамаглал/**



**Зураг 1- 25 Зээлийн хүүний гистограмм /таамаглал, 2018 оны эцэс/**



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа

ДҮГНЭЛТ, ХАВСРАЛТ

4-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА  
2017 ОНЫ IV УЛИРАЛ



## **4. ДҮГНЭЛТ**

### **4.1. Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт**

Судалгааны үр дүнгээс харахад ирэх 12 сарын хугацаанд иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшинээс өснө гэсэн хандлага давамгайлж байна. Иргэд 2018 оны 4 дүгээр улиралд инфляцийг 7.9% /чанарын хариултын хувьд/, 5.8% /тоон хариултын хувьд/, 11.4% /мэдрэмжид суурилсан/ тус тус байхаар хүлээж байна.

Төгрөгийн ханш чангарна гэсэн иргэдийн хүлээлт 2017 оны дунд үеэс эхлэн огцом нэмэгдсэн бөгөөд 2017 оны 4 дүгээр улирлын судалгаагаар иргэд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш цаашид чангарна гэсэн хүлээлттэй байна.

Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжирч, улмаар өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

### **4.2. Аж ахуй нэгжийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт**

ААН-ийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН-үүд инфляци өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж байна. ААН-үүд 2018 оны эцэст инфляцийг 3.7% /чанарын хариулт/, 3.9% /мэдрэмжид суурилсан/, 6.0% /тоон хариулт/ тус тус байхаар хүлээж байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг чангарна гэж хүлээж байна. Ханшийн хүлээлтийн чиглэлийн индекс огцом буурч сүүлийн 6 жилийн хугацааны хамгийн бага утганд хүрсэн бөгөөд энэ нь ААН-үүдийн төгрөгт итгэх итгэл өндөр байгааг илтгэнэ.

Бизнес эрхлэгчдийн дунд зээлийн хүүг буурна гэсэн эерэг хүлээлт нэмэгджээ.

ААН-ийн 75% нь 2018 оны IV улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж хүлээж байна.

Ирэх 6 сарын хугацаанд ААН-үүд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна. Улмаар тэдгээр бизнес эрхлэгчдийн багагүй хэсэг нь ирэх саруудад үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч байгаа гэж үзэхийн зэрэгцээ

цалингийн түвшинг өсч, ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

### **4.3. Шинжээчдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт**

Судалгааны үр дүнгээс харахад шинжээчид инфляцийн түвшинг 2017 оны эцэст 7.0%, харин 2018 оны эцэст 8.1%-д хүрнэ гэж хүлээж байна.

Харин төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг 2017 оны эцэст 2,451 төгрөг, ирэх оны эцэст 2,419 төгрөгт хүрнэ гэж үзсэн нь шинжээчдийн дунд төгрөг ам.долларын эсрэг чангарна гэсэн хүлээлттэй байгааг харуулж байна.



Ирэх 12 сарын хугацаанд мөнгөний бодлого зөөлөрч, улмаар зээлийн хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна.

### ХАВСРАЛТ 1.

**Хавсралт 1 :** Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл Судалгаанд оролцсон нийт иргэдийн 61% нь эмэгтэй, 39% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 32% нь 18-25, 29% нь 26-35, 18% нь 36-45, 13% нь 46-55, 8% нь 56-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. /Хавсралт 1-1, Хавсралт 1-2/

**Хавсралт 1-1: Хүйс**


**Хавсралт 1-2: Нас**



Мөн судалгаанд оролцогчидийн 34% нь бүрэн дунд, 57% нь дээд боловсролтой бөгөөд тэн хагас нь сард 700.000 төгрөгөөс их зардал гаргадаг байна.

**Хавсралт 1-3: Боловсролын түвшин**


**Хавсралт 1-4: Сарын дундаж зардал**



Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 28-ны өдрүүдэд Монгол Улсын Их Сургууль, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Отгонтэнгэр дээд сургуулийн оюутнуудтай хамтран Улаанбаатар хотын 7 дүүргийн 845 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалтыг *Хавсралт 1-5-т* үзүүлэв.

### Хавсралт 1-5: Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт



## ХАВСРАЛТ 2.

Судалгаанд хамрагдсан нийт 346 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийн хэлбэрээр авч 133 (38%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 134 (39%) нь бусад хэлбэрийн, 39 (11%) нь хувьцаат компани, 27 (8%) нь нөхөрлөл болон үлдсэн 13 (4%) нь өөр бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй байгууллагууд байлаа (*Хавсралт 2-1*).

### Хавсралт 2-1 Аж ахуй нэгжийн тоо /өмчлөлөөр/

Аж ахуйн нэгжийн хэлбэр	ТОО	ХУВЬ
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	133	38%
Нөхөрлөл	27	8%
Хоршоо	9	3%
Хувьцаат компани	39	11%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	1%
Бусад	134	39%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>346</b>	<b>100.0%</b>

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан авч үзвэл нийт 346 ААН-ээс үйлчилгээ эрхэлдэг 55%, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 19%, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 5% болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 14% байна (*Хавсралт 2-2*).

### Хавсралт 2-2 Аж ахуй нэгжийн тоо /салбараар, ажилтны тоогоор/

Салбарын ангилал	Ажилчдын тоо /бүлгээр/					Бүгд
	< 10	11-19	20-49	50-100	101 <	
Хөдөө аж ахуй	0%	0%	0%	0%	1%	1%
Уул уурхай, олборлох	0%	0%	0%	0%	1%	1%
Боловсруулах үйлдвэр	0%	1%	1%	1%	2%	5%
Барилга	0%	0%	0%	0%	2%	4%
Б/Ж худалдаа	13%	2%	1%	2%	1%	19%
Үйлчилгээ	38%	7%	3%	3%	4%	55%
Тээвэр	0%	0%	0%	0%	1%	2%
Бусад	9%	2%	1%	0%	2%	14%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>60.8%</b>	<b>11.9%</b>	<b>7.0%</b>	<b>6.8%</b>	<b>13.4%</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан нийт 346 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 60.8% нь 9 хүртэл ажилчинтай, 12% нь 10-19 ажилчинтай, 7% нь 20-49 ажилчинтай, үлдсэн 10% нь 50-с дээш ажилчинтай аж ахуй нэгжүүд хамрагджээ (*Хавсралт 1-2*).


Судалгаанд оролцогч ААН-үүдийн дийлэнх буюу 70% нь ирэх 6 сарын хугацаанд компанийнхаа үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөгүй байна гэж хариулжээ. Харин бизнес эрхлэгчдийн 30% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний тулд ихэнх ААН банкны зээлээр (31%) болон өөрийн хөрөнгөөр (37%) санхүүжүүлнэ гэж хариулсан байна /*Хавсралт 2-3*/.

### Хавсралт 2-3 Ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагааг өргөжүүлэх эсэх

<b>Санхүүжилтийн хэлбэр</b>	<b>Үйл ажиллагаагаа өргөжүүлэх үү?</b>	
	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>
Банкны зээлээр	31%	
Компанийн өөрийн хөрөнгөөр	37%	
Хувьцаа гаргах	1%	
Гадаад эх үүсвэрээр	1%	
Бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	1%	
Тэтгэлэг, тусламжаар	0%	
Хувь хүнээс зээлэх	7%	
Бусад	21%	
<b>НИЙТ ДҮН</b>	<b>30%</b>	<b>70%</b>


Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

## Хавсралт 2-4 Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт




Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа


**Хавсралт 3-1 Инфляци /таамаглал, 2017 оны эцэс/**




**Хавсралт 3-2 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш /таамаглал, 2017 оны эцэс/**



**Хавсралт 3-3 Зээлийн хүү /таамаглал, 2017 оны эцэс/**



**Хавсралт 3-4 Сарын дундаж цалин /таамаглал, 2017 оны эцэс/**



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа